



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/10/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3 Авлага	8
2.8.4 Урьдчилгаа	9
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	9
2.8.6 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ

 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг Утас/Факс: 7058-4203		БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАЗАРГҮР ТАНАА	
<u>2020.03.25</u> № <u>336</u>			
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Булган сумын төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал-дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Булган сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110520266			



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Базаргүр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж гүйцэтгэв.

Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Булган сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Булган сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Булган сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 1,651.9 сая төгрөгийн 2 хувь буюу 33.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 45.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 6 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

- Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 13,326.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, сум хөгжлийн сангийн зээлийн хүүгийн авлагыг бүртгэхдээ хүү, алдангийн орлогын 10,367.9 мянган төгрөгийг тусгаагүй алдааг аудитын явцад залруулж, 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,959.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. ЗДТГ-нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын захирамжаар 1,000.0 мянган төгрөгийг "аймгийн арслан цол" хүртсэн иргэнд дэмжлэг үзүүлж олгосон нь Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

2. ИТХ нь нийт худалдан авалтын 34,8 хувь буюу 1,959.0 мянган төгрөгийн е-баримтыг анхан шатны баримт болгон хавсаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь заалт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 81,856.8 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- *Булган сумын Өндөр хошуу хөгжил ОНӨААТҮГ*: Үр дүнгийн тайлангийн орлогыг тулган шалгахад, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 25,0 сая төгрөгийн засвар үйлчилгээний ажлыг орлогоор бүртгэж авсныг санхүүгийн тайланд залруулсан.
- *Булган сумын Ерөнхий боловсролын сургууль*: Үнэ төлбөргүй хүлээн авсан 2,270.0 мянган төгрөгийн хөрөнгөө худалдан авсан хөрөнгийн дүн дээр нэмэгдүүлэн бичилт хийснийг залруулсан.
- *Булган сумын Эрүүл мэндийн төв*: Үнэ төлбөргүй ирсэн 4 нэр төрлийн 5,215.4 мянган төгрөгийн эмийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулсан.
- *Булган сумын Соёлын төв*: Үндсэн хөрөнгө ангилалд хамаарах хөрөнгийг бараа материал дансанд, бараа материалд хамаарах хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд тусгасан, тооллогын дүнгээс үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн зөрсөн нийт 38,999.5 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 143,545.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 131,251.7 мянган төгрөг, хөрөнгийн эхний үлдэгдэл 143,545.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 131,251.7 мянган төгрөг болж 12,293.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	143,517.0	130,115.4	-13,401.6	
Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	28.3	1,136.2	1,107.9	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	143,545.4	131,251.7	-12,293.7	

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 131,251.7 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 130,115.4 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 1,136.2 мянган төгрөг байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт оны хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн ~~оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна~~ дансны эхний үлдэгдэл 112,483.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 190,240.5 мянган төгрөг болж 78,702.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	473.1	473.1	
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	112,010.7	190,240.5	78,702.9
Бусад авлага			
Зээлийн авлага			
Дүн	112,483.8	190,713.5	78,702.9

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 81,940.3 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн 1 жилийн насжилттай 98,000.0 мянган төгрөгийн авлага

ДОА-2020/10/СТА-ТТЗ



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Сум хөгжүүлэх сангийн 3-4 жилийн насжилттай 35,330.0 мянган төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 5-аас дээш жилийн насжилттай 46,607.0 мянган төгрөгийн авлага
- Шалтгаан нь тодорхой бус ЗДТГ-ын 473,1 мянган төгрөгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү болон алдангийг сумаас мэдэгдэх хуудас болон шүүхэд өгч ажилласан байна.

Зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүйн улмаас дараа дараагийн зээлийн олголтод сөрөг үр дагавартай байна.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт данс хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлгүй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 227,556.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 249,154.0 мянган төгрөг болж, 21,597.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	100,623.0	122,530.7	21,907.7
Түүхий эд материал	2,565.2	2,255.3	
Мал	124,367.9	124,367.9	
Дүн	227,556.2	249,154.0	21,597.8

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 3,507,749.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,568,861.8 мянган төгрөг болж, 61,012.0 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,435,544.2	3,497,721.0	



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Биет бус хөрөнгө	72,305.6	71,140.8
Дүн	3,507,849.8	3,568,861.8

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 55,593.9 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 213,922.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 241,697.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 8,689.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, өцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ данс үлдэгдэлгүй байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,873,75.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,873,754.6 мянган төгрөг буюу өөрчлөгдөөгүй байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/</u>	1,873,754.6	1,873,754.6		
<u>орон нутгийн сан</u>				
<u>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/</u>				
<u>Нэмж төлөгдсөн капитал</u>				
<u>/ТӨҮГ/</u>				
<u>Эздийн өмчийн бусад хэсэг</u>				
<u>/ТӨҮГ/</u>				
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	968,046.7	1,106,292.7	138,246.0	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,149,633.7	1149,633.7		
<u>Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү</u>				
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>				
Дүн	3,991,435.0	4,129,681.0	138,246.0	

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Right, Space After: 0 pt

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдэл өөрчлөгдөөгүй, хуримтлагдсан үр дүнгийн өсөлт нь тайлан оны үр дүнгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 3 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 60,690.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 83,397.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137,4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1,600.0	1387.5	-212.5	86.7
Шууд бус орлого	16,500	19,654.2	3,154.2	119.1
Бууны албан татвар	1590.0	575.0	-1,015.0	32.6
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	700.5	-1,299.5	35.0
Газрын төлбөр / Дуудлага худалдаа/	20,000.0	38,095.3	18,095.3	190.5
Хадгаламжийн хүүгийн орлого	4,500.0	6,048.6	1,548.6	134.4
Торгуулийн орлого	12,000.0	15,654.1	3,654.1	130.5
Бусад орлого	2,500.0	1282.5	1,217.5	51.3
Нийт дүн	60,690.0	83,397.7	22,707.7	137.4

Төсвийн орлого 22,707.7 мянган төгрөгөөр давсан нь дуудлага худалдааны орлого, хүү торгуулийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,559,956.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,436,166.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 123,790.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 774,673.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 558,644.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18,848.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 774673.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 558,644.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 5,016.2 мянган төгрөгийг санхүүжилтийг авсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь гүйцэтгэлээрээ олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 895.0 мянган төгрөгөөр тасарсан нь ЗДТГ-т өөрийн орлогоо бүрдүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал, канон принтерийн үйл ажиллагаа бага хадлангийн орлого нэмэлт дансаар дамжиж байгаагаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,474,414.9 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, туслах үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 30,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 18,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төрийн сангийн дансанд 11,500.0 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийг дээд шатны төсвийн захирагчаас 97,948.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 11,163.5 мянган төгрөг, нийт 109,111.6 мянган төгрөгийн орлогоос бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамжийн бараа материалын зардалд 25.4 мянган төгрөгийг, нормативт зардал 1,204.5 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 106,381.7 мянган



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумдын Засаг дарга нар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс, журамд зөвшөөрөгдөөгүй арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Булган сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн Нэмэлт эрх нээлгэх хүсэлтэд баримтуудыг бүрэн хавсаргаагүй, журамд заасан маягтын дагуу бэлтгээгүй байхад зарцуулалтын эрхийг нээсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна. Төсвийг батлахдаа сумын ИТХ-ын хурлын тогтоолд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгаж байх гэсэн албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж 2019 оны 09 сарын 19 ний 1/306 тоотор хүргүүлж ажилласан байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Булган сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	483 585 441,13	571 119 313,07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	143 545 349,21	131 251 674,75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	143 545 349,21	131 251 674,75
3121	Төгрөг	143 545 349,21	131 251 674,75
31211	Төрийн сангийн харилцах	143 517 025,61	130 115 445,31
31213	Арилжааны банк дахь харилцах	28 323,60	1 136 229,44
33	АВЛАГА	112 483 872,91	190 713 600,91
33400	Эзэлийн хүүгийн авлага		3 404 723,00
335	Бусад авлага	112 483 872,91	187 308 877,91
3351	Байгууллагаас авах авлага	473 100,91	473 100,91
3352	Хувь хүмүүсээс авах авлага	112 010 772,00	186 835 777,00
35	БАРАА МАТЕРИАЛ	227 556 219,01	249 154 037,41
351	Түүхий эд материал	2 565 214,82	2 255 324,82
35110	Тусгай зориулалттай материал	2 565 214,82	2 030 214,82
35130	Эм боох материал		225 110,00
354	Хангамжийн материал	100 623 080,19	122 530 788,59
35410	Бичиг хэргийн материал	1 666 688,00	1 666 688,00
35420	Аж ахуйн материал	64 797 632,89	71 017 572,89
35430	Сэлбэг хэрэгсэл	8 205 000,00	8 205 000,00
35440	Түлш, шатах тослох материал	2 668 965,00	2 668 965,00
35470	Бусад хангамжийн материал	23 101 950,80	38 972 562,70
35600	Мал амьтад	124 367 924,00	124 367 924,00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	3 507 849 810,05	3 568 861 823,28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 507 849 810,05	3 568 861 823,28
392	Биет хөрөнгө	3 435 544 210,05	3 497 721 023,28
39201	Барилга, байгууламж, орон сууц	2 191 022 898,34	2 279 807 398,34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2 765 780,89)	(54 771 160,68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171 206 224,00	185 756 224,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83 169 763,78)	(127 785 504,06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	240 052 649,50	279 544 038,50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158 535 372,94)	(169 907 363,94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207 531 499,88	210 954 149,88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105 762 891,60)	(121 649 546,18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1 112 942 664,53	1 264 925 802,53
39215	Хуримтлагдсан элэгдэл	(144 106 013,99)	(256 269 314,11)
39217	Ном	7 128 097,00	7 116 299,00
393	Биет бус хөрөнгө	72 305 600,00	71 140 800,00
39301	Програм хангамж	15 658 000,00	16 590 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5 326 000,00)	(7 423 000,00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61 973 600,00	61 973 600,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3 991 435 251,18	4 139 981 136,35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3 991 435 251,18	4 139 981 136,35
51	Засгийн газрын хувь оролцоо	3 991 435 251,18	4 139 981 136,35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 873 754 695,04	1 873 754 695,04
512	Хуримтлагдсан үр дүн	968 046 794,33	1 116 592 679,50
51210	Өмнөх үеийн үр дүн	853 598 161,64	968 046 794,33
51220	Тайлант үеийн үр дүн	114 448 632,69	148 545 885,17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 149 633 761,81	1 149 633 761,81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 991 435 251,18	4 139 981 136,35



Булган сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 923 012 850,94	2 423 390 071,20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	13 512 527,31	60 412 644,50
110	Орлогын албан татвар	10 374 720,80	21 041 784,50
